



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 4/227

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2018 оны А 429/257 дугаар хамтарсан тушаал, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд энгийн хог хаягдлыг айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгээс цуглуулах, тээвэрлэх, хог хаягдлын менежментийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зэрэг хог хаягдлыг ангилан ялгах, төвлөрүүлэх, дундын цэг болон "Эко төв"-ийг барьж байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийг үр дүнтэй, хурдан шуурхай зохион байгуулж хуралдаанаас гарсан шийдвэрийг эргэн танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Цэеэрэгзэн)-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажлын хэсэгт шаардагдах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (О.Батмөнх)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010791

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025
оны 04 дугаар сарын 07 өдрийн 1127
дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Чингэлтэй дүүргийн менежер

Ажлын хэсгийн гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс

Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын алба

Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс

Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар

"Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ" ХХК-ний гүйцэтгэх захирал

"Найши трейд" ХХК-ний захирал

Нарын бичгийн дарга:

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс